



МОНГОЛ УЛС
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 13 өдөр

Дугаар А/136

Чингис хот

Шинэ коронавирусын болзошгүй
эрсдэлийг бууруулах талаар авах
зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.1 Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, аймгийн Онцгой комиссын 2020 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 11 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Зорчих тээврийн хөдөлгөөнийг хаасантай холбогдуулан өргөн хэрэглээний барааны үнийн хөөрөгдөл үүсэхээс урьдчилан сэргийлж хүнсний барааны нөөцийг бүрдүүлэх ажлыг яаралтай зохион байгуулж, дүнг 03 дугаар сарын 23-ны дотор аймгийн Онцгой комисст танилцуулахыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга /Ж.Энх-Амгалан/-д үүрэг болгосугай.

2. Шинэ коронавирусын халдварын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн Нэгдсэн эмнэлэгт хүчилтөрөгч өтгөрүүлэгч, хяналтын монитор, сорох аппарат зэргийг худалдан авахад 5000000 /таван сая/ төгрөгийг зарцуулсугай.

3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын нэмэлт дансанд бүрдсэн хандиваас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д зөвшөөрсүгэй.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч /Г.Хэрлэнчулуун/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

20200313